

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМД

Хяналтын журмаар гомдол гаргах тухай

Гомдол гаргагч: "Магнай трейд" ХХК /РД:2082489/

Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, НҮ-ний гудамж, МТ оффис

Утас:93114040

"Магнай трейд" ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Оюунсүвд миний бие Нийслэл дэх Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 221/МА2025/0238 дугаартай магадлалыг эс зөвшөөрч, дараах үндэслэлээр давж заалдах гомдол гаргаж байна. Үүнд:

Байгаль орчны улсын байцаагч Ш.Анхбаярын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр ногдуулсан 0049040 дугаартай шийтгэлийн хуудаст Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчлийг үйлдсэн гэж үзсэн тухайд:

"Магнай трейд" ХХК нь Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 08-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй "Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулах"-ын төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2021 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /9.1.Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэсэн байгууллага боловсруулна./-д заасны дагуу "И Эйч Эм Эм" ХХК-аар боловсруулуулан Байгаль орчин аялал жуулчлалын яамаар батлуулж, улмаар Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /9.2.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна./-д гэж заасны дагуу 2021-2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөн дээрх байгууллагуудаар боловсруулан батлуулж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байсан. /Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2021-2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө хавтаст хэрэгт авагдсан болно./

Магадлалын ХЯНАВАЛ хэсгийн 2-5 дахь хэсгүүдэд нэхэмжлэгч "Магнай трейд" ХХК-ийн гомдлыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь үндэслэлгүй болохыг мөн улсын байцаагч хяналт шалгалт явуулахдаа нөхцөл байдлыг бүрэн тогтоолгүйгээр хууль бус шийдвэр гаргасан болохыг бүхэлд нь хүлээн зөвшөөрсөн боловч Захиргааны хэрэг 106.3.11-д заасныг баримтлын улсын байцаагчийн 0049040 дугаар бүхий шийтгэлийн хуудсыг дахин шинэ акт гаргах хүртэл 3 сарын хугацаагаар түдгэлзүүлж шийдвэрлэсэн нь хуульд нийцээгүй гэж үзэж байна.

Иймд дээрх магадлалыг хүчингүй болгож, гомдлын шаардлагыг бүхэлд нь хангаж өгнө үү.

ЖИЧ: Гомдлын дэлгэрэнгүй тайлбарыг хурал дээр тайлбарлах болно.

ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ



Б.ОЮУНСУВД